

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*Хуулийн төслийн
дэлгэрэнгүй танилцуулга*

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл зорилтын 3.2.1.4.-т “Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална.” гэж, 3.2.1.8-д “Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тусгасан.

Улсын Их Хурлаас Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх, бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих талаар урт болон дунд хугацааны төрийн бодлого, хууль тогтоомжийг батлан, бүсчилсэн хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэн ажиллаж ирсэн хэдий ч бүс нутгийн иргэдийн орлогын түвшин ялгаатай, зарим бараа бүтээгдэхүүний үнэ төвийн бүс, нийслэл Улаанбаатар хотоос харьцангуй өндөр, бүс нутгийн хөгжлийн ялгаа зэргээс үүдэн төвийн бүс, түүнчлэн Улаанбаатар хот руу шилжин ажиллаж, амьдрах иргэдийн эрмэлзэл төдийлөн буурахгүй байна.

Улсын Их Хурал өнгөрсөн хугацаанд орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах боломжоор хангах бодлогын хүрээнд төрийн албан хаагчид үндсэн цалингийн нэмэгдэл олгох, орон нутагт бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг хөнгөлөх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч эдгээр нь зөвхөн төрийн албан хаагчид болон бизнес эрхлэгчдийг хамарч байгаа бөгөөд бүс нутагт амьдарч байгаа нийт иргэдэд чиглэсэн бодлого, арга хэмжээ шаардлагатай хэвээр байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөнийг авч үзэхэд нийслэл Улаанбаатар хотод сүүлийн 3 жилийн хугацаанд жил бүр 31-37 мянган иргэн шилжин ирсэн бол 7-16 мянган иргэн шилжин явсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Цалин хөлсний бүтцийн 2023 оны судалгаагаар Баруун бүс нутгийн иргэдийн үндсэн цалингийн хэмжээ улсын дунджаас 353.7 мянган төгрөгөөр буюу 24.5 хувиар бага байна. Ажиллагчдын нийт цалингийн дунджийг байршил, бүс тус бүрээр харьцуулан авч үзсэн тус судалгааны үр дүнгээр Завхан аймгийн нийт цалингийн дундаж улсын дунджаас 56.3 хувиар бага байгаа нь улсын дунджаас хамгийн бага нь байна.

Үндэсний статистикийн хорооны 2024 оны 2 дугаар сарын Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд үндэслэн гаргасан ажиллагсдын сарын дундаж цалингийн хэмжээгээр баруун бүс хамгийн бага буюу улсын дунджаас 22.8 хувиар бага байна.

Эдгээр судалгааны үр дүн нь алслагдсан баруун бүс нутгийн иргэдийн цалингийн хэмжээ улсын дунджаас доогуур байгааг харуулж байна. Гэтэл улсын дунджаас бага цалинтай тухайн бүс нутагт шатахууны үнэ өндөр, өргөн хэрэглээний зарим бараа бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр байгаа нь иргэдийн амьдралд нөлөө үзүүлж байна.

Тухайлбал, Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн авч үзэхэд АИ92 бензиний үнэ баруун бүсийн аймгуудад Улаанбаатар хотоос 18.1-22.0 хувиар, дизелийн түлш 4.0-9.0 хувиар, гурилын үнэ 4.8-48.7 хувиар тус тус өндөр байна. Үндэсний статистикийн хорооны 2022 оны Монгол Улсын статистикийн эмхэтгэлд тусгагдсан хүний хөгжлийн үзүүлэлтүүдээс авч үзвэл дундаж наслалт, боловсролын түвшин, орлогын индекс тулгуурлан гаргадаг хүний хөгжлийн индексээр баруун бүс нутаг улсын дунджаас 0.062 функтээр бага байгаа нь бусад бүс нутгаас хамгийн доогуур үзүүлэлт байна.

Гадаадын улс орнуудад хүн амын нягтшил багатай, алслагдсан нутагт ажиллаж, амьдарч байгаа иргэдэд зориулсан, бараа бүтээгдэхүүний үнийн зөрүү, өртгийг нөхөхөд чиглэсэн хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг зохицуулалтууд байна.

Түүнчлэн Нийтийн өргөдөл, гомдлын системд нэр бүхий иргэн хувь хүний орлогын албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаар өргөдөл гарган түүнийг дэмжиж 100 мянган хүн гарын үсэг зурсан байна.

Эдгээр үндэслэл, шаардлагыг харгалзан үзэж холбогдох хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл нь нийслэл Улаанбаатар хот, нийслэл Улаанбаатар хотоос 1000 км хүртэл хол алслагдсан, 1000 км-ээс дээш алслагдсан гэсэн 3 шатлалтайгаар тухайн аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогод албан татвар ногдуулах хувь, хэмжээг бууруулах зорилготой.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл 2 зүйлтэй.

Нэгдүгээр зүйлд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг өөрчлөн найруулж, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогод албан татвар ногдуулах хувь, хэмжээг нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг, тус хотод бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 5 хувиар, аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 1000 хүртэл км хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 3 хувиар, 1000 км-ээс дээш алслагдсан бол 1 хувиар тогтоохоор тусгалаа.

Хоёрдугаар зүйлд энэ хуулийн дагаж мөрдөх хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар нийслэл Улаанбаатар хотод, түүнээс 1000 хүртэл км алслагдсан, 1000 км-ээс дээш алслагдсан гэсэн 3 шатлалтайгаар хувь хүний орлогын албан татвар төлөгчийн зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогод албан татвар ногдуулах хувь, хэмжээ буурч тухайн хувь, хэмжээгээр орлого иргэдэд бодит орлого болно. Түүнчлэн шатлалтайгаар цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын албан татварын хувь хэмжээг бууруулснаар алслагдсан бүс нутагт ажиллаж, амьдарч байгаа иргэний гарт үлдэх цалин хөлсийг илүү нэмэгдүүлснээр хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөн багасна.

Энэ хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн ба бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл зорилтын 3.2.1.4.-т “Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална.” гэж, 3.2.1.8-д “Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тусгасан.

Улсын Их Хурлаас Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх, бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийг дэмжих талаар урт болон дунд хугацааны төрийн бодлого, хууль тогтоомжийг батлан, бүсчилсэн хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэн ажиллаж ирсэн хэдий ч бүс нутгийн иргэдийн орлогын түвшин ялгаатай, зарим бараа бүтээгдэхүүний үнэ төвийн бүс, нийслэл Улаанбаатар хотоос харьцангуй өндөр, бүс нутгийн хөгжлийн ялгаа зэргээс үүдэн төвийн бүс, түүнчлэн Улаанбаатар хот руу шилжин ажиллаж, амьдрах иргэдийн эрмэлзэл буурахгүй байна.

Улсын Их Хурал өнгөрсөн хугацаанд орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах боломжоор хангах бодлогын хүрээнд төрийн албан хаагчид үндсэн цалингийн нэмэгдэл олгох, орон нутагт бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг хөнгөлөх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа ч эдгээр нь зөвхөн төрийн албан хаагчид болон бизнес эрхлэгчдийг хамарч байгаа бөгөөд бүс нутагт амьдарч байгаа нийт иргэдэд чиглэсэн бодлого, арга хэмжээ шаардлагатай хэвээр байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөнийг авч үзэхэд нийслэл Улаанбаатар хотод сүүлийн 3 жилийн хугацаанд жил бүр 31-37 мянган иргэн шилжин ирсэн бол 7-16 мянган иргэн шилжин явсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Цалин хөлсний бүтцийн 2023 оны судалгаагаар Баруун бүс нутгийн иргэдийн үндсэн цалингийн хэмжээ улсын дунджаас 353.7 мянган төгрөгөөр буюу 24.5 хувиар бага байна. Ажиллагчдын нийт цалингийн дунджийг байршил, бүс тус бүрээр харьцуулан авч үзсэн тус судалгааны үр дүнгээр Завхан аймгийн нийт цалингийн дундаж улсын дунджаас 56.3 хувиар бага байгаа нь улсын дунджаас хамгийн бага нь байна.

Тухайлбал, Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн авч үзэхэд АИ92 бензиний үнэ баруун бүсийн аймгуудад Улаанбаатар хотоос 18.1-22.0 хувиар, дизелийн түлш 4.0-9.0 хувиар, гурилын үнэ 4.8-48.7 хувиар тус тус өндөр байна. Үндэсний статистикийн хорооны 2022 оны Монгол Улсын статистикийн эмхэтгэлд тусгагдсан хүний хөгжлийн үзүүлэлтүүдээс авч үзвэл дундаж наслалт, боловсролын түвшин, орлогын индекст тулгуурлан гаргадаг хүний хөгжлийн индексээр баруун бүс

нутаг улсын дунджаас 0.062 функтээр бага байгаа нь бусад бүс нутгаас хамгийн доогуур үзүүлэлт байна.

Эдгээр үндэслэл, шаардлагыг харгалзан үзэж цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын албан татварын хувь хэмжээг шатлалтайгаар бууруулж, иргэний бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогод албан татвар ногдуулах хувь, хэмжээг нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг, тус хотод бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 5 хувиар, аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 1000 хүртэл км хол алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй албан татвар төлөгчийн орлогод 3 хувиар, 1000 км-ээс дээш алслагдсан бол 1 хувиар тогтоохоор тусгалаа. Энэ хуулийн дагаж мөрдөх хугацааг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ